



НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Архивын баримтын тооллогын
комисс томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Архивын тухай хуулийн 9.4.1, 24.2, Үндэсний Архивын газрын даргын 2007 оны 06 дугаар сарын 07-ны 59 дүгээр тушаалаар батлагдсан "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар"-ын 4.7, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/688 дугаар захирамж, төвийн даргын 2017 оны А/06 тоот тушаалаар баталсан "Нийгмийн хамгааллын тусгай төвийн хөдөлмөрийн дотоод журам"-ын 2.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн архивын баримтын нэгдсэн тооллогыг зохион байгуулах комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд:

Комиссын ахлагч	Б. Энхдолгор	Нягтлан бодогч
Нарийн бичгийн дарга	Д.Ганзаяа	Даргын туслах, архив, бичиг хэргийн ажилтан
Гишүүд	Б.Нандинцэцэг П.Ариунбилэг Л.Үнэнбат	Нийгмийн ажилтан Сэтгэл зүйч Жижүүр

2. Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын архивын баримтад нэгдсэн тооллого явуулах удирдамжийн дагуу байгууллагын тооллогын ажлын төлөвлөгөө гарган, батлагдсан хуваарийн дагуу тооллого явуулахыг комисс /Б.Энхдолгор/-т үүрэг болгосугай.

3. Тооллогын ажлын дүн мэдээг нэгтгэж, илтгэх хуудсаар ажлаа тайлагнан, төвийн ББНШК-ын хурлаар хэлэлцүүлж, салбар комисст хүргүүлэх ажлыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай зохион байгуулахыг комиссын нарийн бичгийн дарга /Д.Ганзаяа/-д даалгасугай.

ДАРГА  Г.ЦЭРЭНДУЛАМ



318060078

